Чандмань сумын ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй, аймгийн Төрийн сангаас өдөр тутмын хяналт хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

## 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлаас 935947.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 9359.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 1089177.3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 10891.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

## 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Чандмань сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18261.7 мянган төгрөгөөр буюу 1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, өр төлбөр, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Тайлангийн үзүүлэлтүүд | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Авлага | 13,402.3 | 15,902.2 | 2,499.9 |
| Бараа материал | 34,735.0 | 54,364.6 | 19,629.6 |
| Үндсэн хөрөнгө | 2,026,764.9 | 2,022,897.1 | (3,867.8) |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | 2,074,902.2 | 2,093,163.9 | 18,261.7 |
| **Богино хугацаат өр төлбөр** | 1,266.4 | 1,359.9 | 93.5 |
| Цэвэр хөрөнгө, өмч | 2,073,635.8 | 2,091,804.0 | 18,168.2 |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 2,074,902.2 | 2,093,163.9 | 18,261.7 |

Авлага дансны үлдэгдэл 15902.2 мянган төгрөг болж 2499.9 мянган төгрөгөөр өссөн шалтгаан нь ажилчдад олгосон бараа материалыг олгосноос авлага нэмэгдсэн байна.

Авлага дансны үлдэгдэлд он удаан жил болсон 11392.7 мянган төгрөгийг хувь хүмүүс болон байгууллагаас авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 54364.6 мянган төгрөг болж 19629.6 мянган төгрөгөөр өссөн нь БСШУСЯ-аас технологийн кабинетын хичээлийн хэрэглэгдэхүүн үнэ төлбөргүй ирсэн, Ковид-19 цар тахалтай холбоотой эм ариутгалын бодис худалдан авч нөөцөлсөнтэй холбоотой нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2817086.8 мянган төгрөг болж 66288.3 мянган төгрөгөөр өссөн нь сумын ОНХС-ийн хөрөнгөөр спорт заалны завсар хийгдсэн, БСШУСЯамны хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж, тавилга эд хогшим, ном сурах бичгийг үнэ төлбөргүй шилжүүлэн өгснөөс шалтгаалжээ.

Тайлант онд үндсэн хөрөнгийг сумын ИТХ-ын А/11 тоот тогтоолоор 21946.4 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс акталж хасагдсан, биет бус хөрөнгөтэй холбоотой өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1359.9 мянган төгрөг болж 93.5 мянган төгрөгөөр өссөн нь бусад бараа зардлын өглөг нэмэгдсэн, өглөгийн үлдэгдэл байгаа 1163.0 мянган төгрөгийн өглөг нь эзэн холбогдогч нь тодорхойгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2091804.0 мянган төгрөг болж 18168.2 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх үеийн үр дүн данс руу залруулах бичилт хийгдсэн, тайлант онд 18261.7 мянган төгрөгийн ашигтай гарсан зэргээс шалтгаалж байна.

Чандмань сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 168660.5 мянган төгрөгөөр буюу 18 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй 90096.6 мянган төгрөгийн орлогыг хүлээн авсан, тусгай зориулалтын санхүүжилт 99445.1, орон нутгийн төсвөөс санхүүжилт 59531.7 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 133264.4 мянган төгрөгөөр буюу 14 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшил, шимтгэлийн зардал 93841.5, байр ашиглалтай холбоотой тогтмол зардал 38403.8, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 392.0, орон нутгийн төсөвт 22868.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлснээс тус тус өссөн, хангамж бараа материалын зардал 2423.5, эд хогшил, урсгал засварын зардал 84.0, нормативт зардал 6995.4, урсгал шилжүүлэг 6336.9, бараа үйлчилгээний бусад зардал 5007.0, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулалд 6939.7 дотоод томилолтын зардал 791.2 мянган төгрөгөөр тус тус буурчээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 306.9 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь акталсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлтэй холбоотой залруулга бичсэнтэй холбоотой байна.

## 3.6. **ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 835193.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 835193.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 872531.3, орон нутгийн төсвөөс 110959.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 872531.3 мянган төгрөгийг тусгай шилжүүлгээс, орон нутгийн төсвөөс 110110.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 1600.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай шилжүүлгээр 849617.7, орон нутгийн төсвөөс 110110.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 1000.0 мянган төгрөг, нийт 960727.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 960927.9 мянган төгрөгийг зарцуулж 22913.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 960927.9 мянган төгрөг буюу 97.6 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 3489.6, нормативт зардал 14457.2, эд хогшил, урсгал засварын зардал 849.5, томилолтын зардал 225.9, урсгал шилжүүлэг 4978.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээ 22913.6 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой ерөнхий боловсролын сургуулиуд хичээллээгүйгээс шалтгаалсан байна.Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 3 Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт /мян.төг/

| код | хөтөлбөр, арга хэмжээ | мөнгөн дүн |
|---|---|---|
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 12.5 |
| 81801 | Үдийн цай хөтөлбөр | 4,971.8 |
| 81806 | Дотуур байрны үйлчилгээ | 14,903.1 |
| 80305 | Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр | 337.2 |
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 2,689.0 |
| | ДҮН | 22,913.6 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нийгмийн даатгалын хэлтсээс 12421.7 мянган төгрөгийн жирэмсэн амаржсаны тэтгэмж, аймгийн Засаг даргын А/552 тоот захирамжаар БСУГ-аас 500.0 мянган төгрөг нийт 12921.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүнд тэтгэмжийн орлогыг цэвэрлэж тайлагнасан.

Үүнээс бичиг хэргийн зардалд 150.0, тоног төхөөрөмж худалдан авахад 350.0 нийт 500.0 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэлгүй байна.

## 3.7. **Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 140 мэдээллээс хугацаандаа оруулсан 132 мэдээлэл, хугацаа хоцроосон 7 мэдээлэл, 1 мэдээллийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлого, 1, 2 дугаар сарын халаалтын зардал төлсөн ажил гүйлгээ, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн хэмнэлт, хэтрэлтийн тайлбар, шалтгааныг бичээгүй, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлтийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

## 3.8. **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 16275.5 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгөгдөж зөвлөмжийн хэрэгжилт 33.3 хувьтай байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | - | - | - | - | - | - | |
| Албан шаардлага | | | - | - | - | - | |
| Зөвлөмж | 3 | 16,275.5 | 1 | 6,217.9 | 2 | 10,057.6 | 33.3 |
| Нийт дүн | 3 | 16,275.5 | 1 | 6,217.9 | 2 | 10,057.6 | 33.3 |

## 3.9. **Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 76859.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6628.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 8245.9 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 31360.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 30624.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Багш ажилчдад 2732.8 мянган төгрөгийн хүнсний материал худалдан борлуулж авлагаар бүртгээгүй шууд зардалд тусгасан,
2. ХХОАТ-ын 1963.8 мянган төгрөгийн авлагыг цалингийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн,
3. Акталсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг 306.9 мянган төгрөгөөр бууруулаагүй,
4. Өмнөх үеийн үр дүнг 306.9 мянган төгрөгөөр залруулга бичилтийг орхигдуулсан,
5. Тайлант оны үр дүнг 1318.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасантай холбоотой нийт 6628.4 мянган төгрөгийн залруулгыг аудитын явцад хийгдлээ.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулж 6628.4 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлсэн болно.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 39606.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 8245.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 31360.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Эд хариуцагчийн орлогын баримтгүй 1050.0 мянган төгрөгийн материалын үнэ төлсөн, түлээ нүүрсний хөнгөлөлтийг нягтлан бодогчийн дансаар дамжуулан олгож захирлын данс руу 446.1 мянган төгрөгийг шатахууны үнэ, 5045355194 тоот данс руу сойз ариутгагчийн үнэнд 625.0 мянган төгрөгийг олгосон зэрэг нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй, аудитын “үнэн зөв байдал”, “бодитой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх алдаа зөрчилтэй холбоотой 2121.1 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт бичих

2. Багш ажилчдад түлээ нүүрсний хөнгөлөлтөд 25520.0 мянган төгрөгийг цалингийн зардлаас олгож нийгмийн даатгалын шимтгэлийг даатгуулагчаас 2934.8 мянган төгрөгийг суутган аваагүй, ажил олгогчоос 3190.0 мянган төгрөгийг төлөөгүй нийт 6124.8 мянган төгрөгийг 2020 оны 12 дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд тусгаагүй орхигдуулсан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4-д "аж ахуйн нэгж, байгууллагаас ажилтанд олгож байгаа хоол, унааны зардал, орон сууц, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, түүнтэй адилтгах бусад орлого"-д нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна” гэсэн заалттай нийцэхгүй, аудитын “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх”, үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт бичлээ.

3. 2020 оны 1 сараас эхлэн Ковид-19 цар тахалтай улмаас сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явагдаагүйгээс өмнөх онд худалдан авч нөөцөлсөн 1248.0 мянган төгрөгийн 247 кг адууны мах нь муудаж ашиглахгүй боломжгүй болсон боловч байгууллагын өмч хамгаалах зөвлөл, бараа материал устгасан талаарх нотлох баримтуудыг санхүүгийн баримтад хавсаргаагүй, анхан шатны баримтгүй, багш ажилчдад цар тахалтай холбоотой цахим хичээл хийхтэй холбоотой 690.0 мянган төгрөгийг цэвэр бохир усны хэмнэлтээс

олгосон зэрэг нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 6.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцээгүй, аудитын "үнэн зөв байдал", "бодитой байх", "тохиолдсон байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4. Цалингийн зардлаас багш ажилчдад түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр дамжуулаагүй 25520.0 мянган төгрөгийг арилжааны банкаар дамжуулан олгосон, тушаал шийдвэр нь хүчингүй болсон заалтыг үндэслэсэн, хамт олны хурлын шийдвэргүй олгосон, Ковид-19 цар тахалтай холбоотой шатахуун, бараа материал худалдан авахад 3902.7 мянган төгрөгийн ажил гүйлгээг гаргасан болович бодитоор зарцуулсныг нотлох боломжгүй байгаа нь *Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоолын 1-д "Төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлж, төрийн албан хаагчийн орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулах зорилгоор төрийн албаны хүний нөөцийн мэдээлэлд суурилсан төрийн албаны цалингийн нэгдсэн системийг 2020 оны 5 дугаар сараас бүх шатны төсвийн байгууллагад үе шаттайгаар нэвтрүүлэх", Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр 2.2.4-д " төсвийн зарлагын хэмнэлтийг зарцуулах санал (Төсвийн тухай хуулийн 46.3.2, 46.3.3-т заасан арга хэмжээнд зарцуулах бол байгууллагын хамт олны хурлын тэмдэглэл, хуралдааны шийдвэрийн хамт) хүргүүлнэ"* гэсэн заалтуудыг мөрдөөгүй, аудитын "үнэн зөв байдал", "бодитой байх", "тохиолдсон байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 30624.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хүнсний болон шатахууны бараа материалын зарцуулалт, хүнсний материалын худалдан авалтыг холбогдох хуульд заасны дагуу гэрээ, тендер зохион байгуулаагүй байгаа тул дараагийн аудитаар шалгах асуудал байна.

Аудитаар материллаг хэмжээний алдаа зөрчил илэрсэн тул тус байгууллагын санхүүгийн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгч, ТТЗ-ын тайлангаар сахилгын шийтгэл ноогдуулах асуудлыг авч үзэх шаардлагатай.

Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 11 тоот тогтоолоор 1 $м^3$ халаалтын хөлсийг /НӨАТ/-гүй 1400 төгрөгөөр тогтоосны дагуу "Эрдэс тайга" ХХК-тай дулааны эрчим хүчээр хангах, хэрэглэх тухай 01 тоот гэрээг байгуулсан, гэрээний хугацаа 2020 оны 5 сарын 1-нд дууссан, гэрээг шинэчлэн байгуулаагүй, 2020 оны 12 сарын 28-нд 02 тоот гэрээгээр 2021онд нийлүүлэх талаар гэрээг байгуулсан тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй байна.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

***1.Бараа материалын данстай холбоотой асуудал***

1.1. *Илрүүлэлт:* Бараа материалыг тайланг эд хариуцагч нь гаргаагүй нягтлан бодогч нь санхүүгийн программд шивж тайлан гаргасан, хүнсний бараа материалын тайлан дах үлдэгдэл бодитоор оршин байгаа нь тодорхой бус, бараа материалын тайланд 25585.6 мянган төгрөгийн хүнсний материалын зарлагадсан болович анхан шатны баримтгүйгээс нотлох боломжгүй байна.

1.2. *Эрсдэл:* Төсвийн хөрөнгийг үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх, бараа материал нь бодитоор оршин байхгүй байх, бараа материал дутах

1.3. *Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”* , *Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн* 13.6-*д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтуудыг мөрдөж ажиллах*

1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн

2. ***Анхан шатны баримттай холбоотой асуудал***

*2.1. Илрүүлэлт:* Сургуулийн захирлын А/67, А/44, А/09 тоот тушаалаар эх үрсийн баяр, ахмад багш ажилчдад гарын бэлэг өгөх, дотуур байрын 13 сурагчдад хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэхэд хоолны зардлаас 2695.0 мянган төгрөгийг зарцуулахдаа хэдэн хүнд олгосныг нотлох АШБ-гүй байна.

*2.2. Эрсдэл*: Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах,

*2.3. Өгсөн зөвлөмж:* Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг мөрдөн ажиллах

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн.

3***. Зардлын данстай холбоотой асуудал***

3.*1. Илрүүлэлт:* Тайлант онд 2343.4 мянган төгрөгийн шатахуун худалдан авч зарцуулсан, жолоочийн тооцоог бүрэн бодоогүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй, эд хариуцагчийн тайлан гаргаагүй.

*3.2. Эрсдэл*: Тайлан буруу илэрхийлэгдэх, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх.

3.*3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"* гэсэн заалтуудыг мөрдөх, эд хариуцагчийн тайлан гаргаж хэвших

3*.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн

4***. Тооллого хийхтэй холбоотой асуудал***

*4.1. Илрүүлэлт:* Тайлант оны эцэст байгууллагын хөрөнгө, бараа материалд тооллого хийсэн талаар мэдээллийг ирүүлээгүй, ирүүлсэн материал нь 2019 оны 9 дүгээр сарын 10-ны А/63 тоот тушаал тооллого хийсэн тухай холбогдох баримтууд ирүүлсэн, 2020 онд тооллого хийснийг нотлох баримтгүй байна.
*4.2. Эрсдэл*: Тооллого хийгээгүй байх, үр дүнгүй хийгдсэн байх

*4.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-д " түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/*", 72.4-д "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;, 73.2-д "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэсэн заалтуудыг мөрдөх, хөрөнгийн тооллогыг хагас бүтэн жилээр хийж, үр дүнг тооцон ажиллах

*4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн

5.***Шилэн данстай холбоотой асуудал***

*5.1. Илрүүлэлт:* Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн хэмнэлт, хэтрэлтийн тайлбар, шалтгааныг бичээгүй, 5 сая төгрөгөөс дээш орлогын ажил гүйлгээ санхүүжилтийг мэдээгүй, 1.2 дугаар сард төлсөн халаалтын зардлын ажил гүйлгээг мэдээлээгүй, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлтийг мэдээлээгүй байршуулаагүй байна.

*5.2. Эрсдэл*: Мэдээллийг ил тод нээлттэй мэдээлэхгүй байх, хуулийн заалтуудыг мөрдөөгүй байх

*5.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5.төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор;" 6.1.6-д "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"* гэсэн заалтуудыг мөрдөх, мэдээллийг тухай бүр мэдээлж хэвших.

*5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

| Огноо: | Аудитын нэр: | | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2021 | | ***Чандмань сумын сургуулийн* 2020 *оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | ХОА-2021/63/СТА-ТШЗ |

Шалгагдсан байгууллагын нэр: **Чандмань сумын сургууль** Мянган төгрөгөөр

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Цалингийн зардлаас багш ажилчдад түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо шимтгэл суутгаагүй, ажил олгогчоос төлөх шимтгэлийг төлөөгүй, Даатгалын тайланд тусгаагүй орхигдуулсан | 6124.8 | Төлбөрийн акт | | |
| 2 | Эд хариуцагч нь хүлээн аваагүй материалын үнэ төлсөн, нягтлан бодогчийн дансаар дамжуулан түлээ нүүрсний мөнгө олгохдоо захирлын данс руу шатахууны үнэ, 5045355194 тоот данс руу сойз ариутгагчийн үнийг давхардуулан олгосон | 2121.1 | Төлбөрийн акт | | |
| 3 | Өмнөх онд их хэмжээгээр нөөцөлсөн хүнсний материалыг багш ажилчдад олгож авлагаар бүртгэхдээ холбогдох дансны бичилтийг буруу хийсэн | 2732.7 | Залруулга хийх | | |
| 4 | ХХОАТ-ын тооцооны авлагыг цалингийн зардал руу хааж тайланд тусгасан | 1963.8 | Залруулга хийх | | |
| 5 | Тайлант оны үр дүн, өмнөх үеийн үр зөрүүтэй илэрхийлсэн | 1625.0 | Залруулга хийх | | |
| 6 | Акталсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны бичилтийг орхигдуулсан | 306.9 | Залруулга хийх | | |
| 7 | Цалингийн зардлаас багш ажилчдад түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр дамжуулан олгоогүй шууд арилжааны банкаар дамжуулан олгосон, тушаал шийдвэр нь хүчингүй болсон Сангийн сайдын тушаалын заалтаар олгосон, хамт олны хурлын шийдвэргүй олгосон, Ковид-19 цар тахалтай холбоотой шатахуун, бараа материал худалдан авахад 3902.7 мянган төгрөгийн ажил гүйлгээг гаргасан боловч бодитоор зарцуулсныг нотлох боломжгүй | 29422.7 | Албан шаардлага өгөх | Сургуулийн захирал , нягтлан бодогч | Ш.Пүрэвдамба, Н.Болор-Эрдэнэ |
| 8 | Дотуур байрны хүүхдийн хоол хүнсэнд өмнөх онд авч нөөцөлсөн 247 кг адууны махыг оны эцэст зарлагадсан, багш ажилчдад нэгжийн мөнгө олгосон, | 1938.0 | Албан шаардлага өгөх | | |
| 9 | Захирлын тушаалаар эх үрсийн баяр, багш нарын баяраар ахмад багш ажилтан нарын гарын бэлэг бэлтгэх, дотуур байрны 13 сурагчдад хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх хөрөнгө гаргахдаа тушаалын хавсралтгүй санхүүгийн баримтад хэдэн хэнд олгосныг нотлох анхан шатны баримтгүй | 2695.0 | Зөвлөмж өгөх | | |
| 10 | Эд хариуцагчийн тайланг нярав нь гаргаагүй нягтлан бодогч нь санхүүгийн программд шивж тайлан гаргасан, хүнсний бараа материалын тайлан дах үлдэгдэл, зарцуулалтын тооцоог тулгахад анхан шатны баримтууд бүрэн бус хүүхдийн хоол хүнсэнд зарцуулсныг нотлох боломжгүй тодорхой бус, | 25585.6 | Зөвлөмж өгөх | | |
| 11 | Тайлант онд 2343.4 мянган төгрөгийн шатахуун худалдан авч зарцуулсан, жолоочийн тооцоог бүрэн бодоогүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй, эд хариуцагчийн тайлан гаргаагүй. | 2343.4 | Зөвлөмж өгөх | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 12 | Тайлант оны эцэст байгууллагын хөрөнгө, бараа материалд тооллого хийсэн талаар мэдээллийг ирүүлээгүй, ирүүлсэн материал нь 2019 оны 9 дүгээр сарын 10-ны А/63 тоот тушаал тооллого хийсэн тухай холбогдох баримтууд ирүүлсэн, 2020 онд тооллого хийснийг нотлох баримтгүй байна. | - | Зөвлөмж өгөх | | |
| 13 | Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн хэмнэлт, хэтрэлтийн тайлбар, шалтгааныг бичээгүй, 5 сая төгрөгөөс дээш орлогын ажил гүйлгээ санхүүжилтийг мэдээгүй, 1.2 дугаар сард төлсөн халаалтын зардал төлсөн ажил гүйлгээг мэдээлээгүй, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлтийг мэдээлээгүй | - | Зөвлөмж өгөх | | |
| **ДҮН** | | 76859.0 | | | |

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**